



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**Аудитын нэр: ШААМАР СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аудитад хамрагдсан жил: 2023, 2024 он

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “ШААМАР СУМЫН ТТЗ”

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: “ШААМАР СУМЫН ЗДТГ”

АУДИТЫН ТӨРӨЛ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2025.02.03-2025.02.28

АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2025

Тайланг бэлтгэсэн:

**Дотоод аудитын нэгжийн
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн
хяналт, дотоод аудитын газрын
дарга, СХШУАБ Т.Одсүрэн

Аудитын багийн гишүүн:

Ахлах дотоод аудитор
Х.Батбаатар

Дотоод аудитор Г.Дорждэрэм,

Огноо: 2025 оны 02 дүгээр сарын
14 өдөр

Сүхбаатар сумын 2 дугаар баг,
Нутгийн удирдлагын II байр

selenge@sankhuuaudit.se.gov.mn

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,

2.1. Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

2.3. Аудитын арга аргачлал, хязгаарлалт

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1 Засаглалын талаар

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

3.3 Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1 Илэрсэн асуудлууд

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дугаартай удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2023, 2024 оны үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Шаамар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

- Шаамар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;
- Аудитаар тус газрын 2023, 2024 оны үйл ажиллагааг хамруулна. Үүнд:
- Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэх;
- Төсвийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт, хуваарилалт, үр дүн
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүн
- Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн
- Хоршоог хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын үр нөлөө
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн,
- Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын арилгах арга хэмжээ

авч хэрэгжүүлсэн байдал

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023, 2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам
- Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам
- СТОУС, НББОУС болон бусад стандартууд
- Бусад хууль, эрх зүйн актууд

3.1 Байгууллагын сайн туршлага

Шаамар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэж ирсэн.

Тус сумын 1-р багт баригдсан 283.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 450 м дулааны шугам, мөн Шаамар 6 км-ээс Түшиг Шаамар чиглэлийн төв замтай холбосон 6.7 км зам, сумын төв дотор 2.4 км асфальтан зам барилгын ажлууд нь дэд бүтцийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж, иргэдийн зорчих нөхцөлийг сайжруулсан.

Шаамар сумын спорт заалыг 300.0 сая төгрөгөөр шинэчлэн засварласан, мөн сумын иргэдийн хандиваар мэргэжлийн тамирчдын бэлтгэл хийдэг тоног төхөөрөмж бүхий бялдаржуулах танхимыг шинээр байгуулсан хүүхэд залуучууд биеийн тамир спортоор хичээллэх, хүүхэд залуучууд спортоор эрүүлжих таатай орчин бүрдсэн.

3.2 Засаглалын талаар

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын удирдлагын багт ИТХ-ын даргаар Г.Отгонпүрэв, Засаг даргаар М.Ганболд нар 2024 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр томилогдсон байна.

Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2024 онд 83.4 хувь, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 2023 онд 93.7, 2024 онд 94.1 хувь, Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 онд 85.2, 2024 онд 89.0 хувь, аймгийн, хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 2023 онд 62.7, 2024 онд 56.2 хувь, "Аялал жуулчлал-ногоон хөгжлийг дэмжих жил"-ийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 2024 онд 87.2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод ёс зүй, үнэт зүйлсийг үнэлж, дэмждэг "Ёс зүйн дэд хороо"-оог байгуулсан.

Засаглах удирдлага, гүйцэтгэх удирдлагын хооронд эрсдэл, хяналтын талаар мэдээлэл солилцдог.

Сумын Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэхэд гол ажлуудыг шийдвэрлэсэн байна.

3.3 Эрсдэлийн удирдлагын талаар

Эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэхэд эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, байгууллагын үйл ажиллагаанд учрах эрсдэлийг тодорхойлоогүй, энэ талаарх нэгдсэн ойлголт байгаа ч эрсдэлийг урьдчилан тооцоолж бүртгэж үнэлэх арга хэмжээ зохион байгуулаагүй байна. Мөн санхүүгийн үйл ажиллагаа болон эрх бүхий албан тушаалтнаас гарах тушаал шийдвэрийн боловсруулалтад хяналт тавьдаг боловч үр дүнгүй байгаа нь эрсдэлийн удирдлагыг түвшин хангалтгүй байгааг илэрхийлж байна. Тухайлбал:

- Эрсдэлээ бүрэн тодорхойлоогүй, зөвхөн санхүүгийн эрсдэлийг бүртгэдэг.
- Эрсдэлийн удирдлагын талаар нэгдсэн ойлголтгүй.
- Эрсдэлийн мэдээллийг нэгтгэж, удирдлагын түвшинд оновчтой ашиглахгүй байна.
- Эрсдэлийг удирдах тодорхой бодлого, арга хэмжээ байхгүй.
- Залилангийн эрсдэлийг тусгайлан авч үздэггүй.

Удирдлагын "ёс зүйтэй байдлыг дэмжин урамшуулах байдал", ёс зүйгүй үйлдлийн эсрэг хандах хандлага, авах арга хэмжээ буруу, удирдлага шаардлага

тавьсан ч үе шатны хяналтыг дутуу орхигдуулснаас хэрэгжилт нь хангалтгүй. Байгууллагын стратеги, зорилго зорилтыг хангахад тулгарч буй гол эрсдэлүүд:

- Санхүүгийн орлого тасалдах
- Байгалийн гамшигтай холбоотой төлөвлөгдөөгүй зардал гарч болзошгүй
- ОНХС, ХХС, аймгийн болон сумын зарим хөрөнгө оруулалтууд эдийн засгийн үр ашиггүй байх
- Орон нутагт тогтвортой ажиллах боловсон хүчний хомсдол
- Байгууллагын эрсдэлийн үнэлгээг жил бүрийн эхэнд хийдэг ч зөвхөн дотоод хяналтын хүрээнд хязгаарлагдсан байдлаар хэрэгжүүлдэг.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 1-р түвшинд байна.

3.4 Дотоод хяналтын системийн талаар

Байгууллага нь дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулж, улирал бүр санхүүгийн ажил гүйлгээг хянаж баталгаажуулах байдлаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа нь дотоод хяналтыг сулруулж байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаагүйтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	Эрсдэлийн тодорхой хэмжээнд ярилцдаг боловч түүнийг бүртгэж үнэлж бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө бага
Бодит байдал:	Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөхдөө учирч болох эрсдэлүүдийг авч бүртгэж түүнийг бууруулах талаар ярилцдаг боловч баримтжуулаагүй, үнэлгээ хийгдээгүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт-2120, Эрсдэлийн менежмент – Эрсдэлийн үнэлгээний арга MNS ISO 31010:2016
Асуудлын үндсэн шалтгаан:	Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар холбогдох албан тушаалтанд сургалт зохион байгуулаагүй Эрсдэлийг зөвхөн шаардлагатай үед тодорхойлдог боловч эрсдэлээ бүртгэх үнэлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байна.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана.
Шийдвэр:	Байгууллагын албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгч, дотоод хяналтын нэгж хариуцсан ажиллагсдыг сургалтад үе шаттай хамруулж, чадавхжуулах -Гүйцэтгэх удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтан сонгон шалгаруулж авах

-Байгууллагын эрсдэлийн түшинг нэг шатлал ахиулан давтамжтай түвшинд шилжих зөвлөмж хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 2</u>	Малын тоо толгойн албан татварын бодитоор ногдуулаагүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: Татварын хууль тогтоомжийн дагуу малчин өрх бүрийн малын тоо толгойд үндэслэн албан татвар ногдуулах ёстой. Гэтэл малын тоо толгойн албан татварын 2023, 2024 онуудын жилийн эцсийн тооллогын мэдээллийг үндэслээгүй 2023 онд 5,580.0 мянган төгрөг, 2024 онд 5,282.0 мянган төгрөг буюу нийт 10,862.0 мянган төгрөгөөр дутуу ногдуулсан байна. Энэ нь татварын орлого бүрдүүлэлт буурч, орон нутгийн төсвийн орлого тасрах нөхцөлийг бүрдүүлж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох: 5.2-д "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно."	
Асуудлын үндсэн шалтгаан: Малын тоо толгой албан татварын тухай хуулийн хэрэгжүүлээгүй, дотоод хяналт сул байгаагаас шалтгаалсан байна	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Татварын орлого тасалдах, улмаар орон нутгийн төсвийн орлого буурах, төсвийн хөрөнгийг зохистой хуваарилах, зарцуулахад хүндрэл үүсэх.	
Шийдвэр: Татварын хууль тогтоомжийг чанд мөрдөж, малын тоо толгой албан татвар ногдуулалтыг бодит тоо баримтад тулгуурлаж байх албан шаардлагыг хүргүүлэх.	

<u>Илэрсэн асуудал 3</u>	Сумын Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөр болон аймгийн, хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт зорилго, зорилтын, хүрэх үр дүн бүрэн ханаагүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө бага
Бодит байдал: 1.Засаг даргын мөрийн хөтөлбөрийн үнэлгээ: Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт 2023 онд 86.3 хувьтай, 2024 онд 83.4 хувьтай үнэлэгдсэн байна. Хэрэгжилтийн хувь 2024 онд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй. Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам-д заасан үнэлгээгээр "Тодорхой үр дүнд хүрсэн" боловч шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүнд гарч эхэлж байгаа хэдий ч хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай, 2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний үнэлгээ: 2023 онд 62.7 хувь, 2024 онд 56.2 хувьтай тайлагнагдсан. Иймд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг "эрчимжүүлэх шаардлагатай" байна.	

<p>Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт: Дээрх журам-д зааснаар аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрээгүй тул удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.</p> <p>(Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн)</p>
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам-ын 6 дугаар зүйлийн 6.3.1-т "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <p>Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрэх үр дүнгийн шалгуур тодорхой бус хэрэгжүүлэх арга хэмжээг хангалтгүй хэрэгжүүлснээс зорилтод үр дүндээ хүрээгүй байна.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <p>Сум орон нутгийг хөгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй үзүүлэхэд дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ хангалтай үр дүнд хүрээгүй байгаа нь төрийн бодлого шийдвэрийн биелэлт хангагдахгүй байх сөрөг үр дагаврыг үүсгэж байна.</p>
<p>Шийдвэр:</p> <p>Цаашид орон нутагт хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа хэрэгжихүйц зорилго, зорилтыг дэвшүүлж, хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч үр дүнтэй зохион байгуулж төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх зөвлөмж хүргүүлэх.</p>

<u>Илэрсэн асуудал 4</u>	Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан "Сүү хөргөх төхөөрөмж"-ийг одоог хүртэл ашиглагч тодорхойгүй байгаа нь эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг буруулж байна.
<u>Асуудлын ангилал</u>	дунд
<p>Бодит байдал: Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 27,850.0 мянган төгрөгөөр худалдан авсан "Сүү хөргөх төхөөрөмж"-ийг одоог хүртэл ашиглаагүй байна.</p> <p>Төхөөрөмжийг байрлуулах байр савны асуудлыг шийдээгүй, овор хэмжээ том байснаас болж ашиглалтад оруулаагүй. Төхөөрөмжийг иргэдэд эзэмшүүлэхээр авсан боловч овор хэмжээнээс болоод эзэмшин түрээслэх иргэн олдоогүй байна. Төхөөрөмжийг худалдан авахаас өмнө хангалттай судалгаа хийгээгүй, байр савны асуудлыг шийдвэрлээгүй байж худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгийг үр ашигтай, зохистой зарцуулах зарчимтай нийцэхгүй байна. Мөн орон нутгийн төсвийн бодлого төлөвлөлт муу, судалгаа хангалтгүй байгааг харуулж байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"</p>	

Асуудлын үндсэн шалтгаан:
Хөрөнгө оруулалтын бодлого, шийдвэр хангалттай судалгаанд үндэслээгүй, хаана, хэнд ашиглуулах, эдийн засгийн үр өгөөжийг тооцоолохгүйгээр төхөөрөмжийг худалдан авсан нь ашиглалтад оролгүй удаахрах нөхцөл болсон. Мөн төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг зохистой ашиглах, хяналт тавих механизм тогтоогүй байна.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:
Хөрөнгө ашиглагдахгүй удвал тоног төхөөрөмжийн элэгдэл нэмэгдэж, үнэ цэнээ алдах эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын үр ашиг буурч, эдийн засгийн хохиролтой
Шийдвэр:
Цаашид төсвийн хөрөнгө оруулалт хийхдээ хангалттай судалгаа хийж, иргэдийн саналыг харгалзан үзэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, өгөөжийг тооцож төлөвлөх, төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхээс өмнө байр савны асуудлыг шийдвэрлэх, Сумын эзэмшилд байдаг хуучин ахуйн үйлчилгээний барилгыг сүүний цехээр ажиллуулах шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргаж, хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 5</u>	Төсвийн орлогын бүрдүүлэлт нийт дүнгээрээ биелсэн боловч нэр төрлөөр зарим орлого тасарсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө бага
Бодит байдал:	Төсвийн орлогын бүрдүүлэлт нийт дүнгээрээ биелсэн боловч нэр төрлөөр зарим орлого 2023 онд 18,237.8 мянган төгрөг, 2024 онд 61,363.6 мянган төгрөгөөр тасарсан байна. Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелэлтийг тулган шалгахад 2023 онд Бууны албан татвар: -115.00 мянган төгрөгөөр буюу 83.92 хувиар, Малын тоо толгойн албан татвар: -2,239.30 мянган төгрөгөөр буюу 94.67 хувиар, Улсын тэмдэгтийн хураамж: -1,301.70 мянган төгрөгөөр буюу 56.61% хувиар, Хог хаягдлын үйлчилгээний хураамж: -2,758.60 мянган төгрөгөөр буюу 67.5 хувиар, Бусад орлого: -11,823.19 мянган төгрөгөөр буюу 83.80 хувиар, 2024 онд Үл хөдлөх хөрөнгийн албан татвар: -2,220.77 мянган төгрөгөөр буюу 77.8 хувиар, Бууны албан татвар: -210.00 мянган төгрөгөөр буюу 65.0 хувиар, Улсын тэмдэгтийн хураамж: -794.24 мянган төгрөгөөр буюу 73.5 хувиар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр: -9,517.50 мянган төгрөгөөр буюу 76.2 хувиар, Хог хаягдлын үйлчилгээний хураамж: -2,591.90 мянган төгрөгөөр буюу 69.5 хувиар, Газрын төлбөр: -22,597.39 мянган төгрөгөөр буюу 55.7 хувиар Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөр: -7,108.72 мянган төгрөгөөр буюу 28.9 хувиар, Амьтны нөөц ашигласны төлбөр: -323.20 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар, Бусад орлого: -15,999.90 мянган төгрөгөөр буюу 63.5 хувиар тус тус тасарсан байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"
Асуудлын үндсэн шалтгаан:	Суманд татварын байцаагчгүй, татвар хураалтын үйл ажиллагаа хангалтгүй, татвар төлөгчдийг бүртгэх, хяналт тавих систем сул байсантай холбоотой.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Төсвийн орлого бүрэн төвлөрөөгүйгээс шалтгаалан төлөвлөгдсөн зардлуудын санхүүжилтийн эх үүсвэр тасрах, Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж буурах, Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байх

Шийдвэр:

Төсвийн орлогын бүрдүүлэлтийг ангилал тус бүрээр төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэх, ТТЗ төсвийн орлогыг бүрдүүлэхтэй холбоотой татварын байцаагчийг орон нутагт томилон ажиллуулахад мэргэжлийн байгууллагад хандан хамтран ажиллах чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 6</u>	2024 онд сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулсан Эл Си Би ХХК-аар гаргуулаагүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: Төрийн албан хаагчдын байр худалдан авах 220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулсан Эл Си Би ХХК-аар гаргуулаагүй байгаа нь тухайн байгууллагад гэрээний үүргээ биелүүлэх хөшүүрэг, хариуцлага үүрүүлэх нөхцөл боломж бүрдүүлээгүй байгаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 42.1-д “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана”, 42.2-д “Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана”, “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 3.1 дэх “Хуулийн 42.1-д зааснаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас багагүй үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлнэ”	
Асуудлын үндсэн шалтгаан: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн хэрэгжилтийг хангаагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Тухайн байгууллага гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх. Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс байгууллага хохирох.	
Шийдвэр: Цаашид хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаруулан ажиллаж байх албан шаардлага хүргүүлэх.	

<u>Илэрсэн асуудал 7</u>	2024 онд ХХС-ын үйл ажиллагаанд хийгдсэн дотоод аудитаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, давтан гаргасан. ОНХС, ХХС-ын санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн буюу тодруулга, тэмдэглэл бэлтгэж гаргаагүй байна
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их

Бодит байдал:

1. 2024 онд ХХС-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар “Санхүүгийн программд 35 зээлдэгчдийн 200,343,800.0 төгрөгийн авлагыг бөөн дүнгээр бүртгэсэн, зээлдэгч тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй, ХХС-ийн зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2024 оны үлдэгдэл санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй, Санхүүгийн тайланд тусгасан боловч зээлийн авлагын дүнг ХХС-ийн зээлийн мэдээллийн санд бүртгээгүй, зээлийг бүрэн барагдуулаагүй байхад барьцаа хөрөнгийг чөлөөлсөн” зэрэг зөрчилд өгсөн албан шаардлага, зөвлөмжийг арилгаагүй давтан гаргасан байна. Мөн 2024 онд ХХС-аас 60.0 сая төгрөгийн 2 зээл олгосон боловч зээлдэгчийн хувийн хэргийн бүрдэл /Монгол банкны лавлагаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, Хоршоо, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, үйл ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөө/ дутуу, авлагын мэдээллийг санхүүгийн программд бүртгээгүй, зөрчлийг давтан гаргасан.

2. ОНХС, ХХС-ын 2023, 2024 онуудын санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн буюу тодруулга тэмдэглэлийг бэлтгэн гаргаагүй байна. ХХС-ын 2023, 2024 онуудын санхүүгийн тайлан зөрүүтэй байна. Санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлгүйгээр санхүүгийн тайлан нь бүрэн бус, ойлгомжгүй байгаа нь нягтлан бодогч ажилдаа хариуцлагагүй ханддаг, дотоод хяналт сул байгааг харуулж байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-д "...үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,...", Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр дугаар А/3 дугаар тушаалаар баталсан заавар, журам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 6.3-т "Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх хоршоо нь дараах шаардлагыг хангасан байна", 6.3.2-т "Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх", 6.10-д "Сумын Засаг дарга зээлдэгчийн талаарх дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална", 6.10.8-д "зээлийн эргэн төлөлтийн хуваарь", 6.10.10-т "Хоршоо, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, үйл ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөө"-тэй нийцээгүй байна;

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгууллагын дотоод хяналт сул, сан хариуцсан нягтлан бодогч нь зээлийн хувийн хэргийн бүрдэл, зээлийн үйл ажиллагааг хэрхэн зөв бүртгэх, хянах талаарх ойлголт хангалтгүй, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжилтийг хангаагүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Сангийн хөрөнгө бүрэн төвлөрөхгүй байх, алдаа зөрчил арилгаагүй давтан гаргаж байгаа нь сангийн үйл ажиллагаа доголдож эрсдэлд орох

Шийдвэр: Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг хангаж ажиллаагүй, давтан гаргасан албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 8</u>	ХХС-ын хяналтын зардалд 3,380.0 мянган төгрөгийг зарцуулсан нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: ХХС-ийн үйл ажиллагааг газар дээр нь үзэж тулган баталгаажуулахад: Хяналтын зөвлөл нэр төдий, ажлын төлөвлөгөө тайлан байхгүй атал хяналтын зардалд зардалд 2023 онд 1,700.0 мянган төгрөг, 2024 онд 1,680.0 мянган төгрөг, нийт 3,380.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. 2023 он, 2024 оны бараа материалын тайланд анхан шатны баримт байхгүй байна. Эдгээр нь холбогдох журам, зааврыг хэрэгжүүлдэггүй, дотоод хяналт сул байгаатай холбоотой.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7 дах заалт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно",	
Асуудлын үндсэн шалтгаан: Санхүүгийн хяналт сул, санхүүгийн сахилга бат алдагдсанаас голлон шалтгаалсан	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Санхүүгийн сахилга бат алдагдах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хяналтын үйл ажиллагааны үр дүн гарахгүй байх	
Шийдвэр: Хяналтын зардалд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, олгосон 3,380.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.	

<u>Илэрсэн асуудал 9</u>	Сумын төсвийн хөрөнгө оруулалтын чиг үүрэгт үл хамаарах "Халуун үнс нурам хадгалах торх" /193 ширхэг поошиг/-ийг худалдан авч нь Төсвийн тухай хуульд нийцэхгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: Сумын төсвийн хөрөнгөөр (2023 оны 4 дүгээр сард) тус сумын 1,2-р багийн айл өрхүүдэд 7,720.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Халуун үнс нурам хадгалах торх" (193 ширхэг поошиг)-ийг айл өрхүүдэд тараасан байна. Энэ нь сумын төсвийн хөрөнгө оруулалтын чиг үүрэгт хамаарахгүй, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 22 дугаар зүйлийн 22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана"	
Асуудлын үндсэн шалтгаан: ОНХС-ийн болон сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг журмын дагуу төлөвлөөгүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Төсвийн хөрөнгө оруулалтын шалгуур хангахгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөө буурна.	
Шийдвэр: Төсөв батлуулахдаа ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах төсөл арга хэмжээг тусгахгүй байх албан шаардлага хүргүүлэх.	

<u>Илэрсэн асуудал 10</u>	Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр "Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ажлын байрны барилга худалдан авах" төсөл арга хэмжээний жишиг баримт, бичгийг боловсруулах, шалгаруулахдаа бусдад давуу байдал олгосон, мөн эрх мэдлээ урвуулан ашигласан байж болзошгүй байна.
----------------------------------	---

Асуудлын ангилал	Нөлөө их
-------------------------	----------

Бодит байдал:

Газар дээр нь шалгаж, тулган баталгаажуулахад, Аймгийн Засаг даргын 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А/31 дүгээр албан тоотоор аймгийн ОНХС-аар хэрэгжих байна "Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ажлын байрны барилга худалдан авах" ажлыг зохион байгуулах эрхийг тус суманд олгосон байна. Тендерийг Шаамар сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нь 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр нээлттэй зарлаж 4 сарын 07-ны өдөр хаасан бөгөөд Ихэр зоос импекс ХХК ганцаар материал ирүүлсэн гэх боловч ирүүлсэн материал байхгүй байна. Тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар баталсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулаагүй давуу байдал олгосон, мөн шалгуур үзүүлэлтийг хангаагүй байгууллагыг шалгаруулж эрх мэдлээ урвуулан ашигласан байж болзошгүй байна. Барилга нь анх 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдөр иргэн Аюуш овогтой Энхтайвангаас иргэн Батмөнх овогтой Мөнхтөрийн нэр дээр 100.0 сая төгрөгөөр худалдах худалдан авах гэрээгээр шилжсэн бөгөөд Шаамар сумын ЗДТГ-аас 2023 оны 2 дугаар сарын 7-нд зарласан тендерт шалгарснаар 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр 132.0 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулан борлуулсан нь "ашиг хонжоо" харсан байна. ТШЗ 18.2 Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: "Шаардана. - Борлуулалтын хэмжээ: 2022 оны борлуулалтын орлогын хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 5 хувиас багагүй байна" гэж заасан атал Ихэр зоос импекс ХХК нь 2022 онд борлуулалтын орлого байхгүй, тайлан тушаагаагүй байна. Сэлэнгэ аймгийн Татварын газраас 2025 оны 02 сарын 27-ны өдөр ирүүлсэн 154 дугаар албан тоотоор 2022, 2023 онд Ихэр зоос импекс ХХК нь үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татвар төлөөгүй бөгөөд татварын өргүй болохыг тодорхойлсон.

Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/48 дугаар захирамжаар томилогдсон комисс уг барилгыг хүлээн авсан боловч дээр дурдсан зөрчил, хяналтгүй худалдан авалтын улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нөхцөл байдал үүссэн байна. "Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ажлын байрны барилга худалдан авах" ажлыг хэрэгжүүлэхдээ тендерийн баримт бичигт техникийн тодорхойлолтыг хуулийн дагуу нарийвчлан тусгаагүй, барилгын чанар, зах зээлийн үнэд судалгаа хийгдээгүй байна. Мөн барилга байгууламжийн зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, хуульд заасан холбогдох зөвшөөрлүүдийг хүлээлцээгүй нь худалдан авалтын үйл ажиллагаанд хууль, журмын шаардлага хангагдаагүй, тендерийн баталгаа гаргасан эсэх тодорхойгүй байна. Барилгын чанарт хяналт тавигдаагүй бөгөөд хуучирч муудсан шугам хоолой хагарч, засвар үйлчилгээний зардал нэмэгдэх, улмаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан эрсдэл үүсжээ. Уг барилга нь хэдэн онд баригдаж, ашиглалтад орсон нь тодорхойгүй байдалтай байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12 дугаар зүйл. 12.2. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад тавигдах чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана. Сангийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт, Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйл 3.1.2."ашиг хонжоо" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг, эрүүгийн хуулийн 22 дугаар зүйл 22.1.1. Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

Асуудлын үндсэн шалтгаан:

Барилга худалдан авахдаа техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөл, ашиглалтын гэрчилгээг, байгаль орчны үнэлгээ хийлгээгүй, холбогдох зөвшөөрлүүдийг хүлээж аваагүй. Барилгын чанарын болон зах зээлийн үнийн судалгаа хийгдээгүй тул хөрөнгө оруулалтын үр ашиг тооцогдоогүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Засвар, үйлчилгээний зардал нэмэгдэж, дахин төсвөөс хөрөнгө гарах эрсдэлтэй, Төсвийн хөрөнгө оруулалтын зорилго хангагдахгүй, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжихгүй байх

Шийдвэр:

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ажлын байрны барилгыг худалдан авахдаа бусдад давуу байдал олгосон, эрх мэдлээ урвуулан ашигласан байж болзошгүй тул хуулийн байгууллагад шилжүүлэх.

Илэрсэн асуудал 11	Буруутай албан тушаалтны шийдвэрээс төрд учруулсан 9.6 сая төгрөгийн хохирлыг барагдуулалгүйгээр сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/11 дүгээр захирамжийг үндэслэн Хоршоо хөгжүүлэх зээлийн мэдээллийн сан болон санхүүгийн тайлангаас хассан байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Д.Соёлбаатар нь ХХС-аас 2011 онд "Халуун ус, ахуйн үйлчилгээ"-ний байрыг засварлах зориулалтаар 3 жилийн хугацаатай 10 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан, өнөөдрийн байдлаар 9,645,616 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Шаамар сумын Засаг дарга нь 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/11 дугаар захирамжаар Д.Соёлбаатарын зээлийн үлдэгдэл 9.6 сая төгрөгийн зээлийг чөлөөлөх шийдвэр гаргаж, санхүүгийн тайлан, бүртгэлээс хассан байна. Зээлийн үлдэгдлийг чөлөөлөхөөр гарсан захиргааны актад тусгасан хуулийн заалт нь (62.1.23) Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд байхгүй болно.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйл 3.1.3."албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг; Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйл 22.1.1. Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,	

эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйл 60.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх,

Асуудлын үндсэн шалтгаан:

Зээлийн үлдэгдлийг чөлөөлсөн захиргааны актад тусгагдсан хуулийн заалт нь (62.1.23) Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд байхгүй, сум дундын анхан шатны шүүхийн 2017 оны 490 дүгээр тогтоолд зээлээс чөлөөлөх үндэслэл дурдагдаагүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Эрх бүхий албан тушаалтны хууль зөрчин гаргасан шийдвэрийн улмаас ХХС-д 9,645,616.0 төгрөгийн санхүүгийн хохирол учирсан

Шийдвэр:

Буруутай албан тушаалтны шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг хуулийн хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж хохирлыг барагдуулах.

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллага өөрийн зорилгодоо хүрэхийн тулд ажил хэргээ арвигч хямгагч, үр дүнтэй эрхлэн явуулахад сайн зохион байгуулагдсан хяналтын тогтолцоо хэрэгтэй гэдгийг удирдлага ойлгон түүнийг хэрэглэх механизмаа бүрдүүлэх, шийдвэр гаргалтад түүний үр нөлөөг ашиглаж чаддаг байх нь чухал.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 60.0 хувь нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР

Х.БАТБААТАР

ТАЙЛАН ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Г.ДОРЖДЭРЭМ

Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:
ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГА

М.ГАНБОЛД

ТӨСВИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ

Т.НОМИНЧИМЭГ

